

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ

Санамж: Нэгдүгээр хэсэг нь 56 сонгох даалгавартай нийт 76 оноотой. Даалгавар тус бүр 5 сонгох хариулттай. Тэдгээрийн зөвхөн нэг зөв хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.** Амжилт хүсье.

1. Палеолитын доод шатны үргэлжилсэн цаг хугацаа аль нь вэ? /1 оноо/
 А. 100000-40000 жилийн өмнө
 В. 8000-НТӨ III мянган
 С. 12000-8000 жилийн өмнө
 D. 800000-100000 жилийн өмнө
 E. НТӨ III мянганаас- НТӨ IV зуун

2. Дунд палеолитын үеийн гол нээлт аль нь вэ? /2 оноо/
 А. Урлагийн үүсэл тавигдав. В. Газар тариалан эрхлэв. С. Гал эзэмшив.
 D. Мал аж ахуй үүсэв. E. Чулуугаар анхны зэвсэг хийв.

3. Хүснэгт доторх асуултын тэмдгийн оронд тохирох үгийг олоорой /1 оноо/

Үе	Гол нээлт
Палеолитын доод үе	Үлдэц, цуулдас
Неолитын үе	?

- А. Зүймэл зэвсэг В. Шидэгч жад С. Ваар сав D. Төмөр зэвсэг E. Гал
4. Хүрлийн үе, түрүү төмрийн үеийн хүмүүс оршуулгын дурсгал үлдээдэг байжээ. Ийм зориулалттай “Дөрвөлжин булш” хэмээх дурсгал Монгол орны аль хэсгээр тархсан байдаг вэ? /1 оноо/

- А. Төв болон баруун хэсгээр
 В. Зүүн болон төвийн хэсгээр
 С. Баруун болон зүүн хэсгээр
 D. Зүүн болон хойд хэсгээр
 E. Баруун болон хойд хэсгээр

5. Цэгийн оронд тохирох утгыг олно уу /1 оноо/
 Хүрлийн үе түрүү төмрийн үед нүүдэлчдийн нийгэм соёл, аж ахуйн цогц тогтолцоо бүрэлдэж..... бий болов.

- А. Суурин иргэншил В. Нүүдлийн иргэншил С. Төрт улс
 D. Овог E. Хотжилт

6. Хань улс Хүннү гүрнийг эн чацуу хүчирхэг болохыг зөвшөөрч “Энх ургийн гэрээ”-г хэдэн онд байгуулсан бэ? /1 оноо/

- А. НТӨ 133 он В. НТӨ 206 он С. НТӨ 209 он D. НТӨ 198 он E. НТӨ 129 он

7. Хүннү гүрний үед холбогдох түүхэн үйл явдлуудыг зөв дараалалд оруулсан нь аль вэ? /2 оноо/

1. Цинь улс Ордосыг эзлэн авав.
 2. Модунь шаньюй Хань улсын Гаоди хааныг бүслэв.
 3. Хань улс “Энх ургийн гэрээ”-г мөрдөхөөс татгалзаж, Хүннүгийн эсрэг дайтах бодлогод шилжив.

- А. 3,2,1 В. 2,1,3 С. 3,1,2 D. 1,2,3 E. 1,3,2

8. 330 онд Жужанчууд төрт улсаа байгуулжээ. Уг оныг зууны тоололд шилжүүлнэ үү /1 оноо/

- А. III зууны I хагас В. III зууны II хагас С. IV зууны II хагас
 D. V зууны I хагас E. IV зууны I хагас

9. Дорнод аймгийн Хөх нуурийн Өгөөмөр хэмээх газраас төмөр дөрөө илрүүлсэн нь Монголд хамгийн эртнийх юм. Аль улсын үед хамаарах вэ? /1 оноо/

- А. Сяньби В. Хүннү С. Жужан D. Түрэг E. Уйгур



10. **a,b** жагсаалтыг ямар шалгуураар гаргасан бэ? /1 оноо/
 а. Хүннү, Сяньби, Жужан
 б. Түрэг, Уйгур, Киргиз
 А. Угсаа гарвалын ялгаагаар
 В. Оршин тогтносон он цагийн урт богиноор
 С. Нийгмийн хөгжлийн түвшингийн ялгаагаар
 D. Монгол болон Хятад нутагт оршиж байснаар нь
 E. Нүүдэлчид болон суурин иргэншлээр нь
11. Хятадын төрийн түүх “Түүхэн тэмдэглэл”-д Хүннү нар “могой, нохой өдрийг эрхэмлэнэ” хэмээжээ. Энэ баримтад хийсэн дүгнэлтүүдээс аль нь илүү бодитой вэ? /1 оноо/
 А. Түүхэн тэмдэглэл нь зөвхөн Хүннүгийн тухай зохиол байжээ.
 В. Тэд могой, нохойг эрхэмлэн шүтдэг байжээ.
 С. Могой, нохой Хүннү нарын амьдралд чухал үүрэгтэй байжээ.
 D. Хүннү нар 12 жил бүхий тооллын цагалбартай байжээ.
 E. Хүннүчүүд гар урлалд могой, нохойг их дүрсэлдэг байжээ.
12. Уйгур улсад бурхны шашин дэлгэрч байсан боловч, Уйгурын хаад ямар шашныг ивээлдээ авч байсан бэ? /1 оноо/
 А. Бөөгийн шашин В. Исламын шашин С. Манихейн шашин
 D. Христийн шашин E. Бурхны шашин
13. Амбагай хаан охиноо Татарт хүргэж өгөхдөө баригдаж Алтан улсад хүргэгдэн цаазлуулжээ. Амбагай хааны төрийн бодлого аль нь вэ? /1 оноо/
 А. Алтан улсыг эзлэн авах В. Татар улсад дагаар орох
 С. Татар улсыг эзлэн авах D. Татар улсыг ивээлдээ авах
 E. Эв нэгдлийг сахих
14. Монгол улсын хаадыг он цагийн дараалалд зөв оруулсан нь аль вэ? /2 оноо/
 А. Хабул, Хотула, Амбагай, Тэмүжин
 В. Амбагай, Хотула, Есүхэй, Хабул
 С. Хотула, Тэмүжин, Хабул, Амбагай
 D. Хабул, Амбагай, Хотула, Тэмүжин
 E. Тэмүжин, Амбагай, Хабул, Хотула
15. Монгол аймаг улсуудыг газар нутагтай нь зөв тохируулсныг сонгоорой /2 оноо/
 1. Ойн иргэд а. Алтайн, Хангайн нурууг дамнан Эрчис мөрөн хүртэлх
 2. Найман улс б. Байгаль нуур, Баргужин төхөм, Горлог мөрний сав
 3. Мэргид с. Орхон голын адаг
 А. 1b, 2a, 3c В. 1c, 2b, 3a С. 1b, 2c, 3a
 D. 1c, 2a, 3b E. 1a, 2b, 3c
16. Чингис хаанд нэгдэхээс дургүйцсэн Тайчууд, Мэргид, Хатагин, Салжиуд нар хэдэн онд Жамухыг “Гүр” хаанд өргөмжилсөн бэ? /1 оноо/
 А. 1189 он В. 1206 он С. 1203 он D. 1201 он E. 1179 он
17. Чингис хааны хишигтэн цэргийн үүргийг зөв тохируулсныг олно уу /1 оноо/
 А. Хэвтүүл-шөнийн манаа, Торгууд-өдрийн харуул, Хорчин- шадар цэрэг
 В. Хэвтүүл-өдрийн манаа, Торгууд-шадар цэрэг, Хорчин- шөнийн манаа
 С. Хэвтүүл-шөнийн манаа, Торгууд-шадар цэрэг, Хорчин- өдрийн манаа
 D. Хэвтүүл-шадар цэрэг, Торгууд-шөнийн манаа, Хорчин- өдрийн манаа
 E. Хэвтүүл-өдрийн манаа, Торгууд-шөнийн манаа, Хорчин- шадар цэрэг
18. Монголын Их Юань улсын нийслэл хотуудыг сонгоно уу. /1 оноо/
 А. Марага, Тебриз В. Дайду, Шанду С. Султание, Хархорум
 D. Аксу, Карши E. Шанду, Багдад
19. Их Юань улсын захиргаанд байсан улс орнуудыг зөв тодорхойлсон нь аль вэ? /2 оноо/
 А. Иран, Ирак, Азербайжан, Армян В. Монгол, Иран, Афганистан, Бага Ази
 С. Монгол, Хятад, Солонгос, Өмнөд Ази D. Турк, Афганистан, Перс, Араб
 E. Хятад, Солонгос, Ирак, Бага Ази



20. Тогоонтөмөр хаан хэзээ, хаана нас барсан бэ? /1 оноо/
 А. 1388 онд Буйр нуурын ойролцоо В. 1368 онд Дайду С. 1374 онд Хархорум
 D. 1370 онд Инчан /Барс/ E. 1372 онд Шанду хотод
21. Түүхэнд тэмдэглэгдсэн “Түмү-гийн хэрэг” гэгч аль нь вэ? /2 оноо/
 А. Түмэн засагт хаан зүүн, баруун түмнийг эвлэрүүлэх Төв засгийн газар байгуулсан явдал.
 В. 1452 онд Эсэн тайш Тайсун хааныг хороож хаан болсон явдал.
 С. Боди-Алаг хаан ах Гүнбилэгийн хамт Урианхай түмнийг 6 удаа довтолсон явдал.
 D. Алтан хан 1557 онд Хөх нуурыг довтолсон явдал.
 E. 1449 онд Эсэн тайш Мин улсын Инзүн хааныг олзолсон явдал.
22. XV-XVI зууны үеийн Зүүн Монголын хааны шууд захиргаанд байдаг, зүүн гурван түмэнг зөв ялгасан хувилбар аль нь вэ? /2 оноо/
 1. Ордос 2. Цахар 3. Юншээбү 4. Түмэд 5. Халх 6. Урианхай
 А. 2, 5, 6 В. 1, 3, 4 С. 5, 1, 3 D. 6, 1, 3 E. 3, 4, 5
23. Батмөнх даян хааны үед Халх түмэн нь Арын 7 отог, Өврийн 5 отгоос бүрдэж байсан ба Арын 7 отгийг түүний хөвгүүн хэн өвлөн захирч байсан бэ? /1 оноо/
 А. Гэрсэнз В. Алчуболд С. Агваржин
 D. Боди-Алаг E. Гүнбилэг
24. **Далай лам:** Өдгөө шарын шашны тэргүүнээр XIV Далай лам Данзанжамц заларч буй бөгөөд 1989 онд Нобелийн энх тайвны шагнал хүртсэн юм. Далай ламын бүх дүр Монголын түүхтэй ямар нэгэн сэжмээр холбогддог билээ. Тэгвэл Монголоос тодруулсан IV Далай ламын нэр хэн бэ? /1 оноо/
 А. Намхайжамц В. Содномжамц С. Занабазар
 D. Ёндонжамц E. Нэйж тойн
25. Амарбаясгалант хийдийг хэзээ, хэний дурсгалд зориулан барьсан бэ? /2 оноо/
 А. 1748 онд Агваанжамбалданзан
 В. 1586 онд Абтай сайн хан
 С. 1727 онд Занабазар
 D. 1577 онд Алтан хан
 E. 1576 онд Түмэн засагт хаан
26. Дараах ойлголтуудыг утгаар зөв харгалзуулна уу? /2 оноо/
 1. Тод үсэг а. 1686 он
 2. Али гали үсэг б. 1648 он
 3. Соёмбо үсэг в. Аюуш гүүш
 А. 1а, 2б, 3с
 В. 1б, 2с, 3а
 С. 1а, 2с, 3б
 D. 1с, 2а, 3б
 E. 1б, 2а, 3с
27. Халх Монголыг Манжийн харьяанд оруулах ёслол хэзээ, хаана болсон бэ? /1 оноо/
 А. 1686 онд Хүрэн бэлчир
 В. 1640 онд Тарвагтайн Улаан бураа
 С. 1691 онд Долоон нуурт
 D. 1689 онд Ар элстэйд
 E. 1636 онд Мүгдэнд
28. 1655 онд өөрийн дүүгээ Манжийн хааны ордонд барьцаанд явуулсан хан хэн бэ? /2 оноо/
 А. Субадай В. Гомбодорж С. Шолой D. Чахундорж E. Норов



29. “Буурын гэрээ”-гээр Оросын хаант улс ба Манж Чин улсын хилийн заагийг тогтоосноор Буриад монголчууд Оросын эзэнт улсын мэдэлд оржээ. Уг гэрээ хэдэн онд болсон бэ? /1 оноо/
 А. 1771 онд В. 1630 онд С. 1689 онд D. 1607 онд E. 1727 онд
30. 1646 онд харьяат нараа дагуулан Халхын сэцэн хан Шолойг түшихээр ирсэн хүн хэн бэ? /1 оноо/
 А. Сөнидийн Тэнгис ван
 В. Дэгдээхэй мэргэн ахай
 С. Доржжав
 D. Хо өрлөг
 E. Аюук хаан
31. Монгол улс тусгаар тогтнолоо алдсан дотоод шалтгаануудаас **ИЛҮҮЦ** нь аль вэ? /2 оноо/
 А. Хагалан бутаргах бодлого явагдсан.
 В. Эрх мэдлийн хувиарлалт алдагдсан.
 С. Хувийг ашиг сонирхол ихэссэн.
 D. Өвөр зуураа өрсөлдөн тэмцэлдсэн.
 E. Их хааны сүр хүч буурсан.
32. Манжийн эсрэг Халх Монголд гарсан бослого тэмцэл хэрхэн эхэлсэн бэ? /1 оноо/
 А. Амарсанаа цэргээ удирдаж бослого гаргаснаар
 В. Манжийн цэргийн жанжинг хороосноор
 С. Чингүнжав дайны талбараас босож, нутгийн зүг явснаар
 D. Сэвдэнбалжирыг Бээжинд дуудаж гэрийн хорионд хийснээр
 E. Манжийн цэрэг дайрч орж ирсэнээр
33. Монголчуудын тусгаар тогтнолын төлөөх тэмцэл хөдөлгөөнүүдийг он цагийн зөв дараалалд оруулсан хариултыг сонгоорой. /2 оноо/
 1. Байлинга, Мялсэнгэ удирдсан бослого
 2. Цогдалайн удирдсан бослого
 3. Амарсанаа, Чингүнжав нарын удирдсан бослого
 А. 1, 3, 2
 В. 1, 2, 3
 С. 2, 3, 1
 D. 3, 1, 2
 E. 3, 2, 1
34. 1911 оны хувьсгалаар Жавзандамба хутагтыг Монгол улсын хаанд залахдаа ямар цол өргөмжилсөн бэ? /1 оноо/
 А. Монгол улсын Түмэн наст Их хаанаар
 В. Монгол улсын хэмжээгүй эрхт хаанаар
 С. Хэмжээт цаазат шашин төрийг хослон баригч Богд хаанаар
 D. Монгол улсын их хаанаар
 E. Монгол улсын шашин төрийг хослон баригч наран гэрэлт Богд хаанаар
35. 1913 онд “Монгол улсын хязгаарын доторх олон зүйлийн уурхайг нээн шийтгэх дүрэм хэмжээ”-г батлав. Дүрэмд зааснаар олборлосон цагаан алт, очир алмас, эрдэнийн чулууны орлогын хэдэн хувийг татварлах болсон бэ? /1 оноо/
 А. 30-60% В. 5-10% С. 10-15% D. 20-30% E. 20-50%
36. Хужирбуланд цэргийн сургуулийг хэдэн онд байгуулсан бэ? /1 оноо/
 А. 1913 он В. 1914 он С. 1915 он
 D. 1918 он E. 1912 он



37. 1912 онд Монгол цэргүүд Улиастайг чөлөөлжээ. Уг оныг билгийн тоололд шилжүүлнэ
 үү /2 оноо/
 Доорх өгөгдлийг ашиглаж бодоорой.

Аргын оныг билгийн жилд шилжүүлэх арга	Махбодь жил	Гал	Шороо	Төмөр	Ус	Мод
Аргын оныг билгийн жилд шилжүүлэхдээ тухайн аргын оноос 1026-г хасч, гарсан ялгаврыг 60-д хуваасны бүхэл үлдэгдэл нь олох билгийн жилийн дугаар бөгөөд ноогдвор дээр 1-ийг нэмбэл олох билгийн жилийг харьяалах жарны дугаар гарна. Хүснэгтэд буй дугаараар билгийн жил хийгээд түүний махбодыг олно.	Туулай	1	13	25	37	49
	Луу	50	2	14	26	38
	Могой	51	3	15	27	39
	Морь	40	52	4	16	28
	Хонь	41	53	5	17	29
	Бич	30	42	54	6	18
	Тахиа	31	43	55	7	19
	Нохой	20	32	44	56	8
	Гахай	21	33	45	57	9
	Хулгана	10	22	34	46	58
	Үхэр	11	23	35	47	59
	Бар	60	12	24	36	48

- A. XIV жарны усан бар жил
 B. XIV жарны усан хулгана жил
 C. XV жарны усан гахай жил
 D. XV жарны усан хулгана жил
 E. XVII жарны усан нохой жил
38. Ардын засгийн газрын бүтцийг зөв тохируулсан нь аль вэ? /2 оноо/
 A. Гадаад яам-С.Данзан, Цэргийн яам-Д.Сүхбаатар, Шүүх яам-Д.Пунцагдорж
 B. Гадаад яам-С.Данзан, Цэргийн яам-Д.Сүхбаатар, Шүүх яам-Д.Лосол
 C. Гадаад яам-Д.Бодоо, Цэргийн яам-Д.Сүхбаатар, Шүүх яам-Н.Магсаржав
 D. Гадаад яам-С.Данзан, Цэргийн яам-Д.Сүхбаатар, Шүүх яам-Д.Догсом
 E. Гадаад яам-Х.Чойбалсан, Цэргийн яам-Д.Сүхбаатар, Шүүх яам-Д.Чагдаржав
39. Судар бичгийн хүрээлэн хэдэн онд байгуулагдсан бэ? /1 оноо/
 A. 1922 он B. 1921 он C. 1923 он D. 1924 он E. 1925 он
40. Ардын засгийн газраас 1922.01.25-нд “Эзэн хамжлагын харилцааг халах” түүхэн шийдвэр гаргасан. Энэ шийдвэрийн гол ач холбогдол аль нь вэ? /2 оноо/
 A. Улс орон цөөн хүний эрх мэдлээс ангижирсан.
 B. Ард олныг нийгмийн хүлээс, ноёдын мэдлээс салгаж чөлөөлсөн.
 C. Социализмыг байгуулах анхны алхам болсон.
 D. Засгийн бүх эрх ард түмний гарт бүрэн шилжсэн.
 E. Хамжлагад байсан бүх хүн баяжсан.
41. Анхдугаар үндсэн хуулийг хэдэн онд баталсан бэ? /1 оноо/
 A. 1992 он B. 1960 он C. 1924 он D. 1940 он E. 1922 он
42. 1924 оны Үндсэн хууль боловсруулсан комиссын гишүүдийг олно уу /1 оноо/
 A. Э.Ринчино, С.Данзан
 B. Ж.Цэвээн, Ч.Бат-Очир
 C. Ч.Бат-Очир, Х.Чойбалсан
 D. Б.Цэрэндорж, Ж.Цэвээн
 E. Н.Магсаржав, Х.Чойбалсан
43. Шинэ эргэлтийн бодлогын агуулгад аль нь **ХАМААРАХГҮЙ** вэ? /1 оноо/
 A. Социализмын үндэс суурийг байгуулах
 B. Хувийн хөдөлмөр худалдааг хөгжүүлэх
 C. Шашин шүтлэгийг бүрэн чөлөөтэй болгох
 D. Ардын засгийн газрийг бэхжүүлэх
 E. Үндэсний ардчилсан үзлийг чиг баримжаа болгох



44. 1935 онд нийт хүн амын 5.6 хувь нь бичиг үсэгтэй байсан бол 1940 онд хэдэн хувь болж нэмэгдсэн бэ? /2 оноо/
 А. 20.8% В. 40.1% С. 15.7% D. 39.1% E. 30.8%
45. 1935 оны 1 сард Япон улс БНМАУ-д халдаж эзэлсэн газар нутгийг олно уу /1 оноо/
 А. Мэнэнгийн тал В. Байтаг Богд уул С. Хөлөн буйрын орчмын нутаг
 D. Алтайн өвөр бие E. Халхын сүм орчмын нутаг
46. Атар газрыг эзэмших II аян хэдэн онд эхэлсэн бэ? /1 оноо/
 А. 1959 он В. 1961 он С. 1956 он D. 1976 он E. 2008 он
47. БНМАУ, 1972 онд Япон улстай дипломат харилцаа тогтоожээ. Энэ онд дипломат харилцаа тогтоосны хэдэн жилийн ой болох вэ? /2 оноо/
 А. 51 жилийн ой В. 59 жилийн ой С. 48 жилийн ой
 D. 61 жилийн ой E. 58 жилийн ой
48. БНМАУ-тай дипломат харилцаа тогтоосон улс орнуудын он цагийг зөв тохируулсан нь аль вэ? /2 оноо/
 1. Их Британи a. 1987 он
 2. Япон b. 1963 он
 3. АНУ c. 1972 он
 А. 1с, 2а, 3b
 В. 1а, 2b, 3с
 С. 1а, 2с, 3b
 D. 1b, 2с, 3а
 E. 1b, 2а, 3с
49. Монголын ардчилсан холбооны анхны цуглаан хэзээ болсон бэ? /1 оноо/
 А. 1989 оны 12 сарын 09 В. 1990 оны 02 сарын 18 С. 1989 оны 12 сарын 10
 D. 1990 оны 01 сарын 21 E. 1990 оны 03 сарын 07
50. Ардчилсан хүчнийхэн 1990.03.08-ны орой мэдэгдэл гаргахдаа ямар шаардлагыг гол болгож тавьсан бэ? /2 оноо/
 А. МАХН-ын үйл ажиллагааг төрөөс ангид байлгах
 В. МАХН-ын үйл ажиллагааг зогсоох
 С. МАХН-ын аппаратыг төрийн ордноос гаргах
 D. МАХН-ын түүхийг үнэн бодитой шинэчлэн боловсруулах
 E. МАХН-ын Төв хорооны Улс төрийн товчоог огцруулах
51. Цэгийн оронд тохирох үгийг сонгоорой.
 1992 оны Үндсэн хуулиар Ардчилал, хууль ёсыг хамгаалах дээд байгуулга хэмээх цоо шинэ байгуулгыг бий болгов. /1 оноо/
 А. Тагнуулын ерөнхий газар
 В. Авилгалтай тэмцэх газар
 С. Хүний эрхийн үндэсний комисс
 D. Үндсэн хуулийн Цэц
 E. Хууль зүй дотоод хэргийн яам
52. Шинэ үндсэн хуулийн дагуу 1992 оны 6 дугаар сард бүх нийтийн чөлөөт ардчилсан сонгууль 2 дахь удаагаа явагдав. Энэ сонгуульд аль нам ялж, хэдэн суудал авсан бэ? /1 оноо/
 А. Монгол ардын хувьсгалт нам ялж, 50 суудал
 В. Монголын социал демократ нам ялж, 50 суудал
 С. Монгол ардын хувьсгалт нам ялж, 70 суудал
 D. Монголын уламжлалын нэгдсэн нам ялж, 1 суудал
 E. Ардчилсан нам ялж, 50 суудал
53. Мэгжид Жанрайсиг шүтээнийг бүтээн залах ажлыг Ерөнхийлөгчийн зарлигаар гүйтэтгэж, хэдэн оны намар Гандантэгчинлэн хийдэд залсан бэ? /1 оноо/
 А. 2000 он В. 1997 он С. 2003 он D. 2007 он E. 1996 он



54. Ардчилсан хувьсгалын дараагаар түүх судлалын шинэчлэл эрчимтэй өрнөж, олон арван түүхийн бүтээл гарч байсан бөгөөд судалгааны түвшинд бичигдэж, 2003 онд нийтийн хүртээл болсон бүтээл аль нь вэ? /2 оноо/
- A. Монголын нууц товчоо
 - B. Зарлигаар тогтоосон Монгол улсын шастир
 - C. Монголын түүхийн дээж бичиг
 - D. Монгол улсын түүх 5 боть
 - E. Монголын товч түүх
55. 2014 онд Монгол улсын гадаад харилцаанд болсон онцлог үйл явдал аль вэ? /1 оноо/
- A. АНУ-ын ерөнхийлөгч Жорж Буш айлчлав.
 - B. Японы ерөнхий сайд Тошкү Кайфу айлчлав.
 - C. БНХАУ-ын дарга Ши Жиньпин айлчлав.
 - D. НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга К.Аннан айлчлав.
 - E. Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал анх удаа батлагдав.
56. Хүний эрх, эрх чөлөөг хангаж үндсэн хуульт байдлыг бататгаж, хууль дээдлэх ёс, Монгол төрийн залгамж чанар, үндэсний эв нэгдлийг сахин дээдэлж, төрөө бэхжүүлж улс төрийн тогтвортой байдлыг хангах нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлын аль чиглэлд хамаарах вэ? /1 оноо/
- A. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах
 - B. Хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хангах
 - C. Хүний аюулгүй байдлыг хангах
 - D. Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах
 - E. Дотоод аюулгүй байдлыг хангах



ХОЁРДУГААР ХЭСЭГ

Санамж: Хоёрдугаар хэсэг нь 4 даалгавартай тус бүр 6 оноотой. Нийт 24 оноо
Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.

2.1 Чулуун зэвсгийн үечлэлийн он цагийг зөв тохируулахдаа 1-7 хүртэлх өгөгдлөөс сонгож харгалзуулна уу. **/1 өгөгдөл илүү байгааг анхаарна уу/** /6 оноо/

- | | |
|------------------|----------------------------------|
| a. Палеолит | 1. 100000-40000 жил |
| b. Мезолит | 2. 40000-12000 жил |
| c. Неолит | 3. 800000-100000 жил |
| d. Доод палеолит | 4. 8000-НТӨ III мянган |
| e. Дунд палеолит | 5. 800000-12000 жил |
| f. Дээд палеолит | 6. 12000-8000 жил |
| | 7. НТӨ III мянганаас-НТӨ IV зуун |

2.2 Дараах түүхэн үйл явдлуудыг он цагтай нь зөв харгалзуулна уу. /6 оноо/

- | | |
|-----------------------------------|------------|
| a. Дөрвөлжин бичиг зохиогдов. | 1. 1221 он |
| b. Хубилай хаан суув. | 2. 1260 он |
| c. Алтан Ордны улс байгуулагдав. | 3. 1271 он |
| d. Ил хаант улс байгуулагдав. | 4. 1256 он |
| e. Цагадайн улс байгуулагдав. | 5. 1269 он |
| f. Хубилай улсаа Юань гэж нэрлэв. | 6. 1242 он |

2.3 Монголын хаант улсуудын үеийг холбогдох ойлголттой нь зөв харгалзуулна уу. /6 оноо/

- | | |
|----------------|--|
| a. Хошууд улс | 1. Хэрлэн голын сав нутаг |
| b. Ойрад | 2. Хангайн нурууны бүс нутаг, Алтайн нурууны зарим хэсэг |
| c. Өвөр Монгол | 3. Цахар, Түмэд Ордос зэрэг аймгуудас бүрдэж байсан. |
| d. Түшээт хан | 4. Хөх нуур, Төвөдийн нутагт оршиж байсан. |
| e. Засагт хан | 5. Монголын баруун хэсэгт оршиж, дөрвөн голлох аймагтай |
| f. Сэцэн хан | 6. Туул голын хөндий, Орхоны дээд бие Тамирын голын сав |

2.4 1921 оны хувьсгалын түүхэн гол үйл явдлуудыг зөв харгалзуулна уу. /6 оноо/

- | | |
|-------------------------|---|
| a. 1920 оны 10 сарын 02 | 1. “Азийн морин дивиз” Монголд цөмрөн орж ирэв. |
| b. 1921 оны 3 сарын 13 | 2. Хиагтыг гамин цэргээс чөлөөлөв. |
| c. 1921 оны 3 сарын 18 | 3. Ардын түр засгийн газар байгуулагдав. |
| d. 1921 оны 06 сарын 30 | 4. Монгол цэрэг Алтанбулагаас Нийслэл хүрээ рүү хөдлөв. |
| e. 1921 оны 07 сарын 08 | 5. Богдыг хэмжээт цаазат хаанаар өргөмжлөв. |
| f. 1921 оны 07 сарын 11 | 6. Монгол цэргийн гол хүч Нийслэл хүрээнд ирэв. |

